



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

61049 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин баг  
Уурхайчны гудамж, Утас: 70350659  
Цахим шуудан: orkhon\_emg@yahoo.com

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР  
БАЙГУУЛЛАГУУДАД

2021.06.18

№ 01/388

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тушаал хэрэгжүүлэн ажиллуулах  
тухай

ЭМГ-ын даргын "Коронавируст халдвар /Ковид-19/-ыг эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах түр журам батлах тухай" А/66 дугаар тушаалыг хүргүүлж байна. Тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана уу. Үүнд:

1. ЭМГ-ын даргын А/66 дугаар тушаалыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулж, тушаалд заасан чиг үүргийн дагуу ажиллах
2. Гэрээр эмчлэгдэж байгаа Коронавируст халдвартай иргэдийг оношилгоо, эмчилгээн болон эмнэлэгт хэвтүүлэхээр бол хуваарийн дагуу зөвлөн туслах багийн эмч нартай холбогдон зөвлөгөө авч, эмнэлэгт шилжүүлэх
3. Эмнэлэгт шилжүүлэхдээ эмнэлзүйн бүлгийн ахлагч БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Б.Одонтунгалаг /99057151/-т мэдэгдэх
4. Тухайн хүнийг тээвэрлэхдээ амилуулах суурь тусламжийн багаж тоног төхөөрөмжөөр тоногдосон түргэн тусламжийн машинаар тээвэрлэх
5. Нарийн мэргэжлийн зөвлөн туслах багийн ахлагч, багийн эмч нарыг үүрэгжүүлэх, хариуцлагатай ажиллуулах
6. ӨЭМТ-ийн ахлагч батлагдсан тохиолдлыг эмчлэх эмч нарын бүртгэл хөтлөлт, эмчилгээ, үзлэгт давхар хяналт хийж, мэдээг өдөр бүр ЭМГ-ын ХШҮМХ-т ирүүлэх

ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 18 -ны өдөр

Дугаар А/66

Эрдэнэт

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах түр журам батлах тухай”

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөөллийг бууруулах тухай хууль, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны “Түр заавар шинэчлэн батлах тухай” А/227 дүгээр тушаалын 3-р хавсралт “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд мөрдөх халдварын сэргийлэлт, хяналтын түр заавар”, ЭМС-ын 2021 оны “Коронавируст халдар (КОВИД-19) оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай” А/318, “Коронавируст халдарын үед эмнэлгийн эмнэлзүйн зөвлөх баг ажиллуулах тухай” А/317, “Коронавируст халдарын үеийн хариу арга хэмжээний зураглал батлах тухай” А/319, ЭМС-ын ЭМС,СС-ын хамтарсан 67/А/268 дугаар “Коронавируст халдар (КОВИД-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай” ЭМС-ын “Түр журам, үнэлгээний хуудас батлах тухай” А/239, “Түр заавар шинэчлэн батлах тухай” А254 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эмнэлгийн тусламж үйлчилгээний зохион байгуулалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх эмнэлзүйн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тусгаарлах эмнэлэг болон ӨЭМТ-үүдийн гэрээр эмчилгээ хийх эмч, сувилагч нарт зөвлөн туслах, хамтарч ажиллах нарийн мэргэжлийн эмч нарын баг, бүрэлдэхүүнийг хоёрдугаар, эмнэлзүйн болон зөвлөн туслах багийн ажиллах журмыг гуравдугаар, ӨЭМТ-үүдийн ажиллах чиг үүргийг дөрөвдүгээр, Коронавируст халдварын хариу арга хэмжээ, мэдээллийн урсгалын зураглалыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Коронавируст халдвар/КОВИД-19/-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн, хавсарсан эмгэггүй, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг

эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдан 14 ба түүнээс дээш хоносон тохиолдлуудыг гэрээр тусгаарлан, эмчилж хяналт тавьж ажиллахыг ӨЭМТ-үүдийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Батлагдсан тохиолдлуудын хаяг, байршлыг ӨЭМТ-үүд рүү тогтмол цаг хугацаанд мэдээллэх, эргэн хяналт тавих, уг өвчтөнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдэд коронавируст халдварыг илрүүлэх ПГУ шинжилгээнд хамруулахыг ЭМГ-ын НЭМТ-ийн тандалт, хариу арга хэмжээний баг /А.Баярхүү/-д даалгасугай.

4. ӨЭМТ-үүдийн эхний ээлжийн эрэмблэн ангилалтаар эмнэлэгт хэвтүүлэх иргэдийг шуурхай хариу арга хэмжээний баг тээвэрлэх /А.Баярхүү/, гэрийн хяналтад эмчлэгдэж буй иргэдээс биеийн байдал хүндэрч эмнэлэгт хэвтүүлэхэд түргэн тусламжийн машинаар тээвэрлэхийг БОЭТ-ийн захирал /Ц.Наран-Эрдэнэ/ нарт тус тус даалгасугай.

5. Гэрээр эмчлэгдэж буй иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаг алдалгүй шийдвэрлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг эмнэл зүйн багийн ахлагч /Б.Уртнасан, Б.Одонтунгалаг/ нарт үүрэг болгосугай.

6. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хүний нөөцийн дайчилгаанд тодотгол хийж, сургаж бэлтгэх, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллахыг ЭМГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн /Ц.Болор-Эрдэнэ/ -д үүрэг болгосугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ХШҮДАХМэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СУХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын  
2021 оны 06 дүгээр сарын  
18-ний өдрийн 1/16 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АЖИЛЛАХ ЭМНЭЛ ЗҮЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Чиг үүрэг	Албан тушаал
<b>Ахлагч :</b>		
1	Б.Уртнасан	ЭМГ-ын ЯГҮТҮХМэргэжилтэн
2	Б.Одонтунгалаг	БОЭТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
<b>Гишүүд :</b>		
3	Ц.Саранцэцэг	БОЭТ-ийн Халдвартын тасгийн эрхлэгч
4	П.Хишгээ	ЭМГ-ын ЭХТҮХМэргэжилтэн
5	О.Анхбаяр	ЭЧАБЭЗХХМэргэжилтэн
6	С.Гүнчинсүрэн	Хувийн хэвшлийн Чандмань холбооны тэргүүн
7	С.Жаргалсайхан	Өрхийн анагаах ухааны холбооны тэргүүн
8	Ц.Дэлгэрмаа	Жаргалант сумын ЭМТөвийн дарга
9	Х.Нандинцэцэг	БОЭТ-ийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч

Эрүүл мэндийн газрын даргын  
2021 оны 06 дүгээр сарын  
18-ний өдрийн 1/66 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨН ТУСЛАХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

НЭГДҮГЭЭР БАГ					
№	Овог нэр	ЭМБ-уудын нэр	Багийн албан тушаал	Утасны дугаар	Зөвлөгөө өгөх ӨЗМТ-үүдийн хуваарь
1	Б.Батбаяр	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Багийн ахлагч-Яаралтай тусламж эрчимт эмчилгээний эмч	99356007	1. Мөнхийн гэгээ 2. Энхжихмандариваа 3. Нийцэл 4. Үйлсбадрах 5. Жаргалант сумын ЭМТөв
2	Ц.Саранцэцэг	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Халдвартын тасгийн эрхлэгч	99353954	
3	А.Ундрах	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Зүрх судасны эмч	95345294	
4	Т.Соёлмаа	Эрдэнэт сувилал	Уушгины эмч	99366669	
5	Г.Шүрэнгэрэл	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Эх барих эмэгтэйчүүдийн эмч	99081257	
6	М.Уртнасан	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Хүүхдийн тасгийн эрхлэгч	99350521	
7	Ц.Оюунцэцэг	Тайхар эмнэлэг	Мэдрэлийн эмч	99022455	
ХОЁРДУГААР БАГ					
1	Д. Баярхүү	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Багийн ахлагч-Яаралтай тусламж эрчимт тасгийн эрхлэгч	99692244	1. Анхны Оч 2. Мэндцэцэн 3. Учралтбаяр 4. Мөнхсүндрэл 5. Ачит ХХЭмнэлэг
2	Б.Дөлгөөн	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Халдвартын эмч	88060686	
3	Л.Отгонцэцэг	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Уушгины эмч	99356082	
4	Н.Цэцэгээ	Тайхар эмнэлэг	Зүрх судасны эмч	99558640	

5	Д.Цогзолмаа	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Хүүхдийн эмч	88025694	
6	Х.Энхгэрэл	Нейрон эмнэлэг	Мэдрэлийн эмч	99558810	
7	Б.Дэлгэрцогт	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Эх барих эмэгтэйчүүдийн эмч	99271643	


## ЭМНЭЛЗҮЙН БОЛОН НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ БАГИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

### Эмнэлзүйн баг:

- 1.1 Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэл зүйн баг нь Коронавируст халдварын нөхцөл байдалтай уялдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах баг байна.
- 1.2 Эмнэл зүйн баг нь Ковид-19 халдварын шалтгаант нас баралтын хамаарал, нөлөөлөх хүчин зүйлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулна.
- 1.3 Нэн хүнд хэлбэрийн өвчтөнг ЭМЯ-наас томилогдсон зөвлөх багтай телемедицинээр холбогдож зөвлөгөө авах, хамтран ажиллах.

### Нарийн мэргэжлийн зөвлөн туслах баг:

- 2.1 Тусгаарлах түр эмнэлэг, байр болон гэрээр эмчлэгдэж байгаа Коронавирусын халдвартай иргэдийн эрэмбэлэн ангилалт, оношилгоо, эмчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх хамтарч үзлэг, шинжилгээ хийх, эмчилгээг өөрчлөх, эмнэлэгт шилжүүлэх асуудлыг хариуцан ажиллах зөвлөн туслах баг байна.
- 2.2 Зөвлөгөө авах эрүүл мэндийн байгууллага болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зөвлөх багийн гишүүд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн үндсэн тулгуур зарчмыг баримтлан, харилцан хүндэтгэлтэй хандаж, хамтран ажиллана.
- 2.3 Мэргэжил арга зүйгээр хангах үүрэг бүхий зөвлөх багийн ахлагч гишүүд тухай түр эмнэлэг, түр байранд хэвтэж байгаа иргэд, ӨЭМТ-ийн гэрийн хяналтад эмчлэгдэж байгаа иргэдийн биеийн байдал, эмчилгээний талаарх мэдээлэлтэй танилцаж, зөвлөгөө чиглэл өгнө.
- 2.4 Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эмчилгээ, оношилгооны чиглэлээр чадавхжуулах сургалтыг зохион байгуулах.
- 2.5 Зөвлөн туслах баг мэргэжил арга зүйгээр хангасан талаарх мэдээллийг ЭМГ-ын холбогдох мэргэжилтэнд ирүүлнэ.



### ӨЭМТ-ҮҮДИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

#### Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр:

1. ӨЭМТ-үүд Коронавируст халдвар (Ковид-19)-ын эмнэл зүйн хөнгөн хэлбэрээр өвдсөн иргэдийг гэрээр эмчлэхдээ ЭМС-ын 2021 оны "Түр журам, үнэлгээний хуудас батлах тухай" А/239, "Түр заавар шинэчлэн батлах тухай" А/254 дугаар тушаалуудыг мөрдөн ажиллана.
2. ӨЭМТ-үүдийн гэрийн эмчилгээ, хяналтыг хийх эмч, эмнэлгийн мэргэжилтний томилж баталгаажуулна.
3. Уг томилогдсон эмч, сувилагч нар нь ЭМГ-ын тандалтын багаас мэдээлсний дагуу батлагдсан тохиолдлыг эхний ээлжинд гэрт нь очиж эрэмблэн эмнэлэгт хэвтүүлэх заалттай иргэдийг цаг алдалгүй ЭМГ-ын тандалтын багт мэдэгдэж эмнэлэгт хүргүүлэх
4. Гэрийн үзлэг хийхдээ пульсоксиметр, чагнуур, даралтын аппарат, амьсгал тоологч, зайнаас халуун хэмжигийг авч явах
5. ЭМС-ын "Шинэ Коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай" А/318 дугаар тушаалын 5.3.1 дэх заалтын дагуу оношилгоо, эмчилгээ, хяналтыг хийх
6. Гэрээр эмчлэх иргэдийг өдөрт 2 удаа утсаар биеийн байдлыг хянах, ханиалгах, амьсгалын тоо олшрох, цээж давчдах, цустай цэр гарах, өвчин хүндрэх эрсдэлт хүчин зүйл илэрсэн, тухайлбал чихрийн шижин, зүрхний дутагдал, уушгины архаг өвчин, артерийн гипертензи, хорт хавдар, дархлаа дарангуйлагдсан байдал, жирэмсэн, 65-аас дээш настай хүмүүсийг эмнэлэгт шилжүүлнэ.
7. ЭМС-ын 2021 оны А/239 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу өвчтөнг үнэлэх, өвчтөнг өөрийгөө үнэлэх хуудсаар үнэлүүлэх, гуравдугаар хавсралтын дагуу зөвшөөрлийн хуудсыг бөглүүлж гэрт нь үлдээх, гар утсаар баталгаажуулан зургийг авах
8. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон тусгаарлах түр эмнэлгээс Коронавируст халдвар (Ковид-19)-аар эмчлэгдээд гарсан иргэдийг ЭМС-ын А/318 дугаар тушаалын 6 дугаар бүлэг (Шинэ Коронавируст халдварын тохиолдлын хяналт, эмнэлгээс гаргах шалгуур)-ийн дагуу халдварын хөнгөн болон шинж тэмдэггүй хэлбэр батлагдсан тохиолдлын эрүүл мэндийг тусгаарлан хяналт тавих нийт хугацаа 14 хоног бөгөөд эмнэлэгт хэвтсэн хугацааг оруулж тооцох, 7 дугаар бүлэг (Шинэ Коронавируст халдварын дараах хяналт)-ээр халдварын дараах хяналтыг хийх
9. Эмчилгээ, оношилгоо, нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх тайлах сургалтыг тогтмол хийж эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах

## Халдвар сэргийлэлт, хяналтын чиглэлээр

10. Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Заавар журам батлах тухай" А/527 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, зөөвөрлөх, хадгалах, устгах журам батлах тухай" 505 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Түр заавар батлах тухай" А/227 дугаар тушаалын холбогдох шийдвэр заавар, удирдамжуудыг мөрдөнө.
11. Явуулын баг нь хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн зөв хэрэглэх ба бохирдсон, бүрэн бүтэн байдал нь алдагдсан тухай бүрд зааврын дагуу солих, өмсөж, тайлах дэглэмийг чанд мөрдөх, бохирлогдсон хамгаалах хувцас хэрэгслийг түр хадгалах, тээвэрлэх, устгах нөхцлийг бүрдүүлж ажиллана.
12. Хэрэглэсэн хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тусгай хог хаягдлын биоаюулгүйн тэмдэглэгээ бүхий хогийн саванд хаях ба хогийн савыг дүүрч байгаа үед хүчээр дарж чихэх үйлдэл хийхгүй байхаар хог хаягдлыг зайлуулах устгалд өгч ажиллах
13. Явуулын баг нь асгарсан цацагдсан биологийн шингэнийг цэвэрлэх цэвэрлэгээний цомогтой байх ба багийн бүх гишүүд авах арга хэмжээг зөв гүйцэтгэх чадварыг эзэмшсэн байна.
14. Эмнэлгийн мэргэжилтнүүд нь тусламж үйлчилгээ үзүүлэх явцдаа бие биендээ хяналт тавьж ажиллах ба санамсаргүй алдаа гаргасан тохиолдолд нуун дарагдуулахгүйгээр өөрийгөө тусгаарлах, хяналтын шинжилгээнд хамрагдах
15. Батлагдсан тохиолдлын гэрт Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Түр заавар батлах тухай" А/227 дугаар тушаалын дагуу голомтын эцсийн халдваргүйтгэлийг хийж мэдээллийг журмын дагуу ЭМГ-т тайлагнаж ажиллана.
16. Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь батлагдсан тохиолдолтой ажилласан албан хаагчдыг халдвараас сэргийлэх урсгал зохицуулалтыг бүрэн хийж ажилчдын усанд орох, хувцасаа солих нөхцлийг бүрдүүлсэн байна.
17. Ажлын байранд 2-3 ээлжийн хувцас, гутлыг бэлтгэж, батлагдсан тохиолдлыг үзэхэд өмссөн дотуур хувцасыг ӨЭМТ-д сольж угаалгын машинд угаах, индүүдэж халдваргүйтгэх
18. Батлагдсан тохиолдолтой ажилласан эмнэлгийн ажилтнууд халдвар хамгаалалын дэглэмийг сайтар сахиж мөрдөсний дараа өрхийн эрүүл мэндийн төвийн үндсэн үйл ажиллагаандаа оролцох

Эрүүл мэндийн газрын даргын  
2021 оны 06 дүгээр сарын  
18-ний өдрийн 1/66 дугаар  
тушаалын тавдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛЫН ЗУРАГЛАЛ

